



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/82/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэнханд

Утас: 99147999

Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа	9
4.2 Төлбөрийн акт	9
4.3 Албан шаардлага	9
4.4 Зөвлөмж.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СОЁЛ
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
С.ЦАГААНБААТАР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.10 № 157

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, шинээр өглөг, авлага үүсгэсэн, төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн, няравын шатахууны тайланг гаргаагүй, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, тооцоог бодоогүй, шатахууны авлагыг НББ-д тусгаагүй орхигдуулсан, татварын хэлтсийн тодорхойлолтоор авлагатай зэрэг нийт 41.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07030016

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	10,417,122.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	18,800.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	18,800.00
3121	Төгрөг	0.00	18,800.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	18,800.00
33	АВЛАГА	0.00	3,815,622.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	815,622.35
335	Бусад авлага	0.00	3,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага		3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	6,582,700.00
354	Хангамжийн материал	0.00	6,582,700.00
35420	Аж ахуйн материал	0.00	6,582,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	3,620,042.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	3,620,042.84
392	Биет хөрөнгө	0.00	3,620,042.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	4,124,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(504,657.16)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	14,037,165.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	18,189.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	18,189.75
413	Өглөг	0.00	18,189.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	18,189.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	14,018,975.44
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	14,018,975.44
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	14,018,975.44
51220	Тайланг үеийн үр дүн	0.00	14,018,975.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	14,037,165.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	71,649,404.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	33,480,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	7,301,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,301,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,177,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	4,124,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	26,178,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	26,178,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	38,169,004.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	38,169,004.00
131103	31 НХЗДНХөрөнгө, түүнтэй адитгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	7,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	31,139,004.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	57,630,428.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	57,630,428.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	57,620,877.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	26,014,131.90
210101	Үндсэн цалин	0.00	26,014,131.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	3,318,898.50
210201	Гэтгэврийн даатгал	0.00	2,437,078.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	275,568.65
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	55,113.73
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	551,137.30
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	6,381,300.00
210401	Бичиг хэрэг	0.00	54,500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	5,357,800.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	0.00	517,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	451,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	21,401,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	21,401,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	504,657.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	504,657.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	9,551.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	9,551.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	9,551.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	14,018,975.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	14,018,975.44

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	14,018,975.44	0.00	14,018,975.44
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	14,018,975.44	0.00	14,018,975.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	67,524,704.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	29,355,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	3,177,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,177,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,177,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	26,178,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	26,178,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	0.00	38,169,004.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	38,169,004.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	7,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	31,139,004.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	67,505,904.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	67,496,353.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	67,496,353.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	26,435,467.00
210101	Үндсэн цалин	0.00	26,435,467.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	3,713,546.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	2,887,179.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	206,592.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	144,058.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	62,533.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	413,184.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	7,675,950.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	6,655,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	290,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	29,671,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	29,671,390.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	9,551.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	9,551.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	9,551.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	18,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	18,800.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	18,800.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,178,700.0	26,159,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,178,700.0	26,159,900.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,178,700.0	26,159,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,906,300.0	22,887,500.00
210101	Үндсэн цалин	22,906,300.0	22,887,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,272,400.0	3,272,400.00
210201	Тэтгэврийн даатгал	2,587,200.0	2,587,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	171,300.0	171,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	137,000.0	137,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	34,300.0	34,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	342,600.0	342,600.00
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,178,700.0	26,178,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,178,700.0	26,178,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,178,700.0	26,178,700.00 18,800.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл ₮
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,159,453.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,159,453.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,159,453.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,529,167.00
210101	Үндсэн цалин	3,529,167.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	441,146.00
210201	Тэтгэврийн даатгал	299,979.00
210202	Тэтгэмжийн даатгал	35,292.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,058.00
210204	Ажилгүйдлийн даатгал	28,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	70,584.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,675,950.00
210402	Тээвэр, шатахуун	6,655,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	290,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,513,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,513,190.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,551.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	9,551.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,169,004.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,169,004.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,139,004.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Соёл урлагийн газрын чиг үүрэг нь соёл, урлагийг хөгжүүлэх, түүх соёлын өвийг хамгаалах, сэргээхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бусад бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулж мөрдөөгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 57.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1.15 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 0.92 сая төгрөгөөр тогтоосон.

Шинээр байгуулагдсан хэлтэс тул гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардлаас сонгосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 10.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Тайлант онд 3.8 сая төгрөгийн авлага үүссэн нь НДШ-ийн болон шатахууны авлага байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 15.5 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 5.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 6.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 4.1 сая төгрөг байгаа нь хэлтэс шинээр байгуулагдсантай холбоотойгоор хандиваар авсан тоног төхөөрөмж байна.

Орлого 33.5 сая төгрөг байгаа нь нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 14.0 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 217.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 191.1 сая төгрөгөөр бууруулж 26.2 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 26.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 26.2 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3.2 сая төгрөгийн санхүүжилт авч бүрэн зарцуулсан байна.

Шинээр хэлтэс байгуулагдсантай холбоотойгоор боловсролын газраас шилжсэн ажилтны цалин 3.2 сая төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 26.2 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн дээд шатны төсөв захирагчаас 31.2 сая төгрөг, нөөц хөрөнгөнөөс 7.0 сая төгрөг нийт 38.2 сая төгрөгийн орлого орж, 38.1 сая төгрөгийг зарцуулж, 0.009 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна. Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын зардал, үндэсний бичигтэн аймаг болох аяны зардлуудад 38.1 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 53.0 сая төгрөгийн 12 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 41.6 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод бүрэн байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 2.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр байгуулагдсан газар тул өмнөх онд аудитад хамрагдаагүй, өмнөх шийдвэрийн үлдэгдэлгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар анхан шатны баримтын бүртгэл хөтлөлт, бараа материалын тайлангийн зарцуулалт, эд хөрөнгийн тооллого, жолоочийн тооцоо бодсон акт, өглөг авлага, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулан мөрдөж ажилласан эсэх, төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн ажилтан ажиллаж байгаа эсэхийг тус тус шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.0 сая төгрөгийн алдааг залруулж, 29.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 2.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн. Санхүүгийн байдлын тайланд 3.0 сая төгрөгийн шатахууны авлагыг тайлагнаагүй байсныг аудитын явцад залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Нийгмийн даатгалын хэлтэст 0.8 сая төгрөгийг тооцоо нийлээгүй, урьдчилж шилжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин салбарын хэмжээнд сургалт, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулахад 11.4 сая төгрөгийг, шагналын зардалд 6.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. 1.5-д "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;" 1.3-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн

нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайлан болон нягтлан бодох бүртгэл 3.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 0.4 сая төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ыг цалингийн зардлаас төлсөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 1.7 сая төгрөгийн шатахуун гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" /Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаал/-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нэг ажилтны 12 дугаар сарын цалин 0.76 сая төгрөгийг урьдчилж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-т "Цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтсон өдөр олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгана." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 53.0 сая төгрөгийн 12 мэдээллээс 41.6 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Няравын шатахууны тайланг гаргаагүй, жолоочийн тооцооны хуудрсыг бүрэн хөтлөөгүй, 1.3 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг зөрчсөн, заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Үндэсний бичигтэн сум байгууллага шалгаруулах тэмцээний шагналд 3.2 сая төгрөгийг олгосон боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасныг зөрчсөн, заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хаан банкинд Соёл урлагийн газрын нэрээр 5337371319 дугаартай данс нээлгэн, 0.018 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр

ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Соёлын газар	13	41.1	3	12.0	0	0	10	29.1	0	0
	Дүн	13	41.1	3	12.0	0	0	10	29.1	0	0